



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Гарын үсэг зурах эрх олгох тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, Улсын Их Хурлын 2009 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын 1.4, 3.1.5, 4.3, 6.7, 8.2, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 9.1-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсад цөмийн энергийн салбарыг хөгжүүлэх, орчин үеийн цөмийн техник, технологийг нэвтрүүлэх, Бүгд Найрамдах Солонгос Улсын энэ чиглэлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бий болгох хүрээнд Засгийн газар хоорондын “Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн Бүсийн төв (Бүгд Найрамдах Солонгос Улсад байрлах)-тэй байгуулах харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах эрхийг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд олгосугай.

2. Байгууллага хоорондын гэрээ байгуулах журамд заасны дагуу санамж бичгийг Гадаад харилцааны яаманд бүртгүүлэн зөвшөөрөл авахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд үүрэг болгосугай.

3. Санамж бичгийн хэрэгжилт, үр дүнг холбогдох журам, дүрмийн дагуу тайлагнахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-нд даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХ-АМГАЛАН

0100067